

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код : 45.020

Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт. 4-р хэсэг: Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтад тавих шаардлага	MNS 6630-4 : 2023
Vehicle numbering of Rolling stock Part 4 : Identification marking for special vehicles.	MNS 6630-4 : 2016

Стандартчиллын үндэсний зөвлөлийн оны дүгээр сарын-ний өдрийн дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь Олон улсын төмөр замын тээврийн гэрээ, эрх зүйн хэм хэмжээний баримт бичиг, мөн Монгол Улсын үндэсний хууль тогтоомжийн дагуу төмөр замын тээврийн байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох, нэгдсэн мэдээлэл, бүртгэлийн өгөгдлийн баазыг бүрдүүлэн ажиллах, мэдээллийн системийн журмыг мөрдөхөд үндэслэх баримт бичиг болох мөн бүртгэгдсэн хөдлөх бүрэлдэхүүний техникийн магадлагаа болно.

Олон улсын болон орон нутгийн төмөр замын тээвэрт ашиглах төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтын тэмдэглэгээ нь суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч болон хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч нарын хоорондын харилцаа, холбоо болон үйл ажиллагааг үндсэн нэг хэл дээр зохицуулан, зохион байгуулах нөхцлийг хангахад хамаарна.

Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтыг дахин давтагдахгүй тоо болон үсгээр тэмдэглэхдээ энэхүү стандартын шаардлагад нийцүүлсэн байна.

Харин суурь бүтцийн техникийн засвар үйлчилгээ болон хяналт, барилга угсралтын зориулалт бүхий хоппер, думкар мөн үе болон зам төмөр зөөвөрлөх хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтын энэхүү стандартад хамаарахгүй.

2 Нэр томьёо, тодорхойлолт

Энэхүү стандарт нь “Төмөр зам. Зам. замын аж ахуйн нэр томьёо, тодорхойлолт” MNS 6387-1:2013 ашигласан болно.

MNS 6630-4 : 2016

3 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах эш татсан стандарт, зөвлөмжийн баримт бичгүүдийг хэрэглэсэн. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд тухайн стандарт, зөвлөмжийн баримт бичгийн хамгийн сүүлийн хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

- 3.1** MNS 6387-3:2013 “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний нэр томьёо, тодорхойлолт”;
- 3.2** MNS 5833:2014 “Төмөр замд барилга байгууламжийн ойртолтын болон хөдлөх бүрэлдэхүүний овор хэмжээ”;
- 3.3** MNS EN15273-2:2016 “Төмөр замын хэрэглээ. 2-р хэсэг. Овор. Хөдлөх бүрэлдэхүүний овор”;
- 3.4** MNS EN15380-1,2,3:2016 Төмөр замын хэрэглээ. Вагон түүний эд ангид тэмдэг, тэмдэглэгээ, бичлэг хийх шаардлага;
- 3.5** MNS EN 15877-1,2:2016, Төмөр замын хэрэглээ–Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн дээр тэмдэг, тэмдэглэгээ тавих;
- 3.6** MNS 6630-1:2016 ” Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт.1-р хэсэг. Төмөр замын зорчигчийн вагоны дугаарлалтад тавих шаардлага”,
- 3.7** MNS 6630-2:2016 ” Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт.2-р хэсэг. Төмөр замын ачааны вагоны дугаарлалтад тавих шаардлага”,
- 3.8** MNS 6630-3:2016 “Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт. 3-р хэсэг Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтад тавих шаардлага”
- 3.9** MNS 6630-4:2016 “Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт. 4-р хэсэг Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтад тавих шаардлага”
- 3.10** MNS 6631-14:2016 Төмөр замын тээврийн харилцаанд хэрэглэгдэх Улс ороны нэгдсэн тоон кодчилал;
- 3.11** O+P 913 “Хөдлөх бүрэлдэхүүний хяналтын тоог тодорхойлох журам”
- 3.12** EN-14033-1”Төмөр замын тусгай хөдлөх бүрэлдэхүүн болон техник, хэрэгслийн баримт бичигт тавих шаардлага”

4 Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтад тавих шаардлага

4.1 Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт

Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт 6 хэсэг бүхий 12 оронтой тооноос бүрдэнэ. Үүнд:


- а) Тусгай хөдлөх бүрэлдэхүүний төмөр замын бүсийн код эхний нийт 2 ороны тоо тодорхойлно. (2 тоо)
- б) Тусгай хөдлөх бүрэлдэхүүнийг бүртгэсэн улсын код дараагийн 2 ороны тоо (2 тоо)

в) Тусгай хөдлөх бүрэлдэхүүний өмчлөгчийн код 2 ороны тоо (2 тоо)

г) Тусгай хөдлөх бүрэлдэхүүний төрөл ангиллыг тодорхойлох 2 ороны тоо (2 тоо)

д) Тусгай хөдлөх бүрэлдэхүүнд үйлдвэрлэгчээс олгосон дугаарыг үндэслэсэн дэс дугаар 3 ороны тоо (3 тоо)

е) Хяналтын тоо нь сүүлийн ороны тоо болно. (1 тоо)



1-р схем. Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний 12 оронтой тоон дугаарлалтын систем

4.2 Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний төрөл, ерөнхий дугаарыг тодорхойлох

Төмөр замын хамтын ажиллагааны байгууллагуудын Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүнийг бүртгэсэн улсын дугаарлалтын эхний хоёр ороны тоо бүгд адилхан ерөнхий дугаар бүхий **99 тоо** байна. Энэ нь Олон улсын төмөр замын байгууллагууд төмөр замын, замын ажлыг гүйцэтгэхдээ замын тусгай хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгчтэй хийж, шаардлагатай газарт авч ажиллуулахад нээлттэй байдлаар хэрэглэх үүднээс тогтоосон тоо болно.

4.3 Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүнийг бүртгэсэн улсын дугаар, кодыг тодорхойлох

Тухайн улсад бүртгэгдсэн Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтын тэмдэглэгээг O+P 920-14: “Төмөр замын тээврийн харилцаанд хэрэглэгдэх Улс орны нэгдсэн тоон кодчилал” заавал мөрдөх зөвлөмжийн баримт бичигт заасан дагуу хийнэ. Монгол Улсын код, тэмдэглэгээг 1-р хүснэгтэд заасан дагуу тэмдэглэж бичсэн байна.

1-р хүснэгт - Монгол Улсын төмөр замын код, лого тэмдэглэгээ

Төмөр замын хамтын ажиллагааны байгууллагад харьяалагдах улс	Үсгэн тэмдэглэгээ	Монгол улсын төмөр замын код	Монгол улсын төмөр замуудын лого
МОНГОЛ	MGL	31	 Монголын төмөр замууд-

4.4 Монгол Улсын төмөр замын бүртгэлийн тэмдэглэгээ, тоон код

Төмөр замын хамтын ажиллагааны байгууллагад харьяалагдах Монгол Улсын төмөр замын бүртгэлийн тэмдэглэгээ, тоон код, үсгэн тэмдэглэгээг дараах хүснэгтэд үзүүлэв.

**2-р хүснэгт - Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүн
өмчлөгч байгууллагын код**

Д/д	Төмөр замын ачааны вагоны өмчлөгчийн нэр	Төмөр замын байгууллагын лого	Төмөр замын ачааны вагон өмчлөгчийн код	Төмөр замын ачааны вагоны өмчлөгчийн тэмдэглэгээ
1	“Улаанбаатар төмөр зам” ХНН		01	УБТЗ ХНН
2	“Монголын төмөр зам” ТӨХК		02	МТЗ ТӨХК
3	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	 “ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”ХХК	06	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ
4	“Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК		07	ЭДЦС ТӨХК
5	“Багануур” ХК	 БАГАНУУР ХК	10	Багануур ХК
6	“Шарын гол” ХХК	 ШАРЫН ГОЛ 1965	12	
7	“Тавантолгой төмөр зам” ХХК	 ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК	16	
8	п...	п...	35	
9			п...	

Тайлбар: Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч бүр код, тэмдэг тэмдэглэгээтэй байх ба өмчлөгч өөрчлөгдсөн тохиолдолд дугаар, лого, тэмдэглэгээ, код солигдож болно. Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний өмчлөгч байгууллага татан буугдсан болон шинээр өөрчлөн зохион байгуулагдсан бол шинэ байгууллагад хуучин өмчлөгчийн нэр, лого, тэмдэглэгээг олгож болно.

- Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний өмчлөгч байгууллагын код дараах байдлаар бичигдсэн байна.

жишээ нь: 99 31 01 ХХХХХ-Хяналтын тоо

99 Төмөр замын хамтын ажиллагааны

байгууллагын бүх гэшүүн улсын Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүнийг тодорхойлно;

- 31 Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөгч тухайн улсын бүртгэлийн код.
01 Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний өмчлөгчийн код

4.5 Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт төрөл, ангиллыг тодорхойлох

Төрөл, ангилал нь хоёр оронт тоо байх ба түүнийг хавсралт №А-д заасны дагуу тодорхойлно.

4.6 Дэс дугаарлалтын тоог тодорхойлох

Дугаарлалтын 9-өөс 11 байрлалд дэс тоог тодорхойлон үзүүлнэ. (дэс дугаар 001-999 байна). Дэс дугаарлалтын тоо нь үйлдвэрлэгчээс олгосон дугаарлалтыг үндэслэсэн дэс тоо байна.

4.8 Хяналтын тоо

Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний хяналтын тоо нь хөдлөх бүрэлдэхүүний дугаарын баруун талд богино зураасаар тусгаарлагдан тэмдэглэгдсэн байна. Хяналтын тоог 913 “Хяналтын тооны бүртгэлийн дугаар” заавал мөрдөх зөвлөмжийн баримт бичигт заасан дагуу тодорхойлно. (В хавсралтаас үзнэ үү.). Хяналтын тоо нь хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтын нийт 11 ороны тоонд хамаарах бөгөөд тэдгээртэй хамтран дугаарыг бүрдүүлнэ.

5 Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний тэвшин /бүхээг, арал г.м/ дээрх тэмдэг, тэмдэглэгээ

5.1 Тусгай хөдлөх бүрэлдэхүүний дугаар

Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний бүтэн дугаарыг эсвэл сүүлийн 6 оронг бичиж тэмдэглэнэ. Жишээ нь:

99 31 01 **23101-7** эсвэл 23101-7

Тухайн улсын төмөр замын дотоодын дүрэм, журмын шаардлагаар бүтэн эсвэл сүүлийн 6 оронтой дугаарыг түүний хэлбэр хийц, загвараас шалтгаалан MNS6630-1, 2, 3:2023 стандартад зааснаас аль тохирохыг авч тэмдэглэнэ.

5.2 Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтын тэмдэг, тэмдэглэгээнд тавих шаардлага

Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтын тэмдэг, тэмдэглэгээг их бие болон арал дээр тавина. Их бие дээрх бичиглэлийн эхний баганад Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүнийг бүртгэсэн улсын лого, код байх ба Монгол Улсын төмөр замын код-31, лого “сүлд”-г зэргийг тэмдэглэн бичсэн байх мөн 2 болон 3-р баганад тусгай хөдлөх бүрэлдэхүүний өмчлөгчийн код, лого, дугаарыг тэмдэг, тэмдэглэгээ бичиглэлтийг энэхүү стандартын дагуу давхардалгүй, зөв, ойлгомжтой тэмдэглэсэн байх шаардлагатай.

Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтын системийг шинэчлэх, энэхүү стандартын дагуу шинээр дугаарлалтын бичилтийг хийх зэрэг үйл ажиллагааг үе шаттайгаар, мөн дунд болон их засварын хийсний дараа өөрчлөн бичиж болно.

Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний техникийн үндсэн үзүүлэлтийн тэмдэг тэмдэглэгээг тэвш /бүхээг, арал г.м/ бичиж тэмдэглэсэн байна.

5.3 Ялгах тэмдэглэгээ

Тусгай хөдлөх бүрэлдэхүүний хоёр талд бэхэлсэн ялгах самбар дээр хөдлөх бүрэлдэхүүний эзэмшигчийн тухай холбоо барих мэдээллийг тэмдэглэх шаардлагатай. (EN 14033-1 стандартын F хавсралт заасан). Мөн баталгаажуулсан тэмдэглэгээ тавьсан байх шаардлагатай.

ТАЙЛБАР: ¹ "Хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч" гэж хугацааны турш хөдлөх бүрэлдэхүүн ашиглаж байгаа этгээдийг хэлнэ.

² "Төмөр зам. Зам төмөрт тавих Замын техникийн шаардлага." 1-р хэсэг: Төмөр замын, замын машин ашиглалт

ТӨГСӨВ.

А1. Төмөр замын, замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний төрөл болон техникийн үзүүлэлт (7,8-р ороны тоо)

А.1-р хүснэгт - Хөдлөх бүрэлдэхүүний төрөл, ангилал, дэд ангилал техникийн үндсэн үзүүлэлт

7-р орон	8-р орон	тайлбар
0 Зам галт тэрэгний бүрэлдэхүүн ба сум тавигч /зам төмөр тавигч, зам тавигч/	1	Зам тавигч краны УК 25/9, УК 25/9-18
	2	Хөдөлгүүрт тавцан МПД, МПД-2 /Моторная платформа дизельная/
	3	Зам тавигч кран КЖУ-571, УК-25/25 / Путьукладочный кран/
	4	Сум тавигч кран УК-25СП, УК-25/28СП,
	5	
1 Зам чигжээслэгч ба өргөгч машинууд (чигжээслэгч, төмөр зам өргөгч, тракторан тугнагч);	1	Цахилгаан чигжээслэгч ЭЛБ-3, ЭЛБ-3МК, ЭЛБ-4/Электробалластер/
	2	Чигжээс тохируулагч ПБ, ПБ-01 /Планировщик балласта/
2 Чигжээсийн давхрага цэвэрлэгч машинууд (буталмал чулуу цэвэрлэх машин);	1	Буталмал чулуу цэвэрлэгч машин СЧ-600, СЧУ-800
	2	Буталмал чулуу цэвэрлэгч машин RM-80, RM-76
	3	Буталмал чулуу цэвэрлэгч машин ЦОМ-6Р, ЦОМ-6БМ
	4	Чигжээс цэвэрлэгч машин БМС
	5	Ваакум цэвэрлэгээний машин МВУ-18000 /Машина путевая вакуумная уборочная/
	6	Зам ба суман шилжүүлгийн чигжээс цэвэрлэгч машин RM /Балластоочистительная машина для путей и стрелочных переводов/
	7	
3 Чигжээсийн призмийг нягтруулах ба зам засах машинууд	1	Дэр чигжигч машин ШПМ-02 /Шпалоподбивочная машина/
	2	Зам засан чигжих машин ВПО-3000, ВПО-3-3000 /Выправочно-подбивочно-отделочная машина/
	3	Зам тогтворжуулагч машин ДСП, ДСП-С4 /Динамический стабилизатор пути/
	4	Зам өргөн чиг татан, чигжих машин ВПР-1200, ВПР-02 /Выправочно-подбивочно-рихтовочная машина/
	5	Зам ба сум өргөн чиг татан, чигжих машин ВПРС-500, ВПРС-02М /Выправочно-подбивочно-рихтовочная стрелочная машина/
	6	Чиг таха машин Р-2000 /Рихтовочная машина/
4 Зам гагнах ба өнгөлөх машинууд	1	Замын төмөр гагнах машин ПРСМ-3 ПРСМ-4 ПРСМ-5 /Путевая рельсосварочная машина/
	2	Зам төмөр өнгөлөх машин РФП-1, РШП-48К /Рельсофрезерный поезд/
5 Хяналт ба хэмжилтийн техникууд	1	Хэт авианы сэв хайгч тэргэнцэр УДС2-РДМ-22 /Ультразвуковой дефектоскоп/
	2	Зам хэмжигч тэргэнцэр ПТ-7МК /Путеизмерительная тележка/
	3	Зам хэмжигч вагон Декарт, КВЛ-П /Вагон-путеизмеритель/
	4	Сэв хайгч вагон ВД-УМТ-1, ВД-УМТ-2, ВД-1МТ 5К /Вагон-дефектоскоп/
6 Цас цэвэрлэх машинууд	1	Цас цэвэрлэгч хусуур СС-1 /Струг-снегоочиститель/
	2	Цас цэвэрлэгч СДП, СДПМ / Снегоочиститель/
	3	Цас цэвэрлэгч СМ-2М, СМ-5, СМ-6 /Снегоуборочная машина/
	4	Элс цэвэрлэгч машин

7 Замын тээвэрлэх, зөөвөрлөх ажилд зориулагдсан машинууд	1	Мотовоз АГМу
	2	Ачааны автомотрис АГД
	3	Дрезина ДГКу
8 Төмөр замын сумт кранууд болон бусад замын машинууд	1	Төмөр замын сумт кран КЖДЭ-16, КЖДЭ-25 /Краны на железнодорожном ходу/
	2	
9 Бусад		

**В хавсралт
(мэдээллийн)**

В1.Хяналтын тоог тодорхойлох дүрэм (О+Р 913 зөвлөмжийн баримт бичиг)

Дугаарлалтын хяналтын тоог дараах байдлаар тодорхойно. Үүнд:

- Үндсэн тоон тэгш байрлалын тоо (Баруун талаас тоолох) нэгжийн утгаар хүлээж авна (өөрөөр хэлбэл 1-ээр үржүүлнэ);
- Үндсэн тоон сондгой байрлалын тоог (Баруун талаас тоолон) 2-оор үржүүлнэ;
- Үржүүлж гаргасан сондгой байрлал дах бүх тоо, сондгой байрлал дах бүх тооны нийлбэрийг тооцоолон, үр дүнг гаргана.
- Хүлээн авсан нийлбэрт бидэнд нэгжийн оронгийн байрлал чухал;
- 10-ыг гаргаж авахын тулд нэгжийн байрлалд тоог нэмж ялгааг гаргах хэрэгтэй, энэ нь хяналтын тоо юм. Хэрвээ нэгжийн байрлалд 0 байх юм бол хяналтын тоо нь 0 байна.

ЖИШЭЭ:

1. Үндсэн дугаар	9 9 8 1 9 2 3 1 0 1 4
Тоон коэффициент	2 1 2 1 2 1 2 1 2 1 2
	18 9 16 1 18 2 6 1 0 1 8

НИЙЛБЭР: $1+8+9+1+6+1+1+8+2+6+1+0+1+8=53$

Нэгжийн байрлалд 3 гэсэн тоо байгаа тул хяналтын тоог тодорхойлохдоо 10–аас нэгжийн байрлалд байгаа тоог хасахад гарсан тоогоор илэрхийлнэ. ЖИШЭЭ нь: $10-3=7$ болно.

Үндсэн дугаар: 99 81 9 231 014–7 бүртгэлийн дугаар болно.

2. Үндсэн дугаар	9 9 5 6 9 6 8 4 1 3 2
Тоон коэффициент	2 1 2 1 2 1 2 1 2 1 2
	18 9 10 6 18 6 16 4 2 3 4

НИЙЛБЭР: $1+8+9+1+0+6+1+8+6+1+6+4+2+3+4=60$

Нэгжийн байрлалд байгаа тоо 0-тэй тэнцүү тул хяналтын тоо “0” байна. Иймд хяналтын тоо–0, Үндсэн дугаар нь 99 56 9 684 132-0 бүртгэлийн дугаар болно.

